

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг:dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaa@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Баян суварга аудит ХХК-ийн захирал С. Должинсүрэн Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/349
танай _____-ны № _____-т

ЦУС СЭЛБЭЛТ, СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд цус, цусан бүтээгдэхүүний захиалга, хэрэглээ өссөнтэй холбоотой 30000 донороос цус, цусан бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагын захиалгыг хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлийн санхүүжилт олгох болсонтой холбоотой захиалагч байгууллагууд цус, цусан бүтээгдэхүүний төлбөрийг төлж чадахгүй болсон тул авлага 965,330.2 мянган төгрөгөөр, өр төлбөр 137,491.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 90.4 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichigl\2024\0223 SNAG-52.Docx

0001051272

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,745,636,413.75	7,710,225,036.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,471,315.17	180,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,471,315.17	180,000.00
3121	Төгрөг	1,471,315.17	180,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,471,315.17	180,000.00
33	АВЛАГА	688,547,729.32	1,653,877,909.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	46,058,704.55	667,121.41
33300	Татаас, санхүүжилтийн авлага	545,222,408.32	501,321,264.93
335	Бусад авлага	97,266,616.45	1,151,889,523.40
3351	Байгууллагаас авах авлага	97,242,816.45	1,151,824,323.40
3352	Хувь хүмүүсээс авах авлага	23,800.00	65,200.00
34	УРЬДЧИЛГАА	2,564,672.21	7,578,456.22
34600	Урьдчилж гарсан зардал	2,564,672.21	7,578,456.22
35	БАРАА МАТЕРИАЛ	5,053,052,697.05	6,048,588,670.93
351	Түүхий эд материал	2,874,588,409.24	3,344,341,094.09
35110	Тусгай зориулалттай материал	801,998,890.00	1,034,640,050.00
35130	Эм боох материал	2,072,589,519.24	2,309,701,044.09
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,016,643,168.00	2,441,018,400.00
354	Хангамжийн материал	161,821,119.81	263,229,176.84
35410	Бичиг хэргийн материал	23,409,123.57	43,124,722.15
35420	Аж ахуйн материал	82,136,750.37	130,267,724.09
35430	Сэлбэг хэрэгсэл	20,438,000.00	59,145,700.00
35440	Түлш, шатах тослох материал	799,003.87	857,556.60
35450	Барилгын засварын материал	9,800,545.00	7,930,534.00
35460	Хүнсний материал	4,942,897.00	4,987,240.00
35470	Бусад хангамжийн материал	20,294,800.00	16,915,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,532,845,990.00	6,495,025,653.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,532,845,990.00	6,495,025,653.90
392	Биет хөрөнгө	7,394,669,973.80	6,358,685,533.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,998,749,529.00	4,096,353,756.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(392,414,104.12)	(462,804,238.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,800,000.00	41,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,153,333.17)	(16,003,333.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,289,975,450.27	10,199,252,418.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,994,534,649.83)	(7,884,611,388.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,114,898,487.49	1,091,780,882.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(653,948,705.38)	(708,281,952.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,001,488.00	7,001,488.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,704,188.46)	(5,802,099.34)
393	Биет бус хөрөнгө	138,176,016.20	136,340,120.07
39301	Программ хангамж	79,622,055.00	81,122,055.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28,807,278.80)	(32,143,174.93)
39303	Бусад биет бус хөрөнгө	87,361,240.00	87,361,240.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,278,482,403.75	14,205,250,690.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	74,998,011.50	212,489,801.84
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	74,998,011.50	212,489,801.84
413	Өглөг	74,704,971.50	211,076,761.84
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	91,786.96
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	205,632,166.08
4136	Бусад өглөг	74,704,971.50	5,352,808.80

41361	Байгууллагад төлөх өглөг	31,509,020.00	5,152,808.80
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	43,195,951.50	200,000.00
414	Урьдчилж орсон орлого	293,040.00	1,413,040.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	293,040.00	1,413,040.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,203,484,392.25	13,992,760,888.95
51	Засгийн газрын хувь оролцоо	13,203,484,392.25	13,992,760,888.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,838,458,653.00	2,838,458,653.00
51101	Өмч: - төрийн	2,838,458,653.00	2,838,458,653.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,778,480,043.15	10,567,756,539.85
51210	Өмнөх үеийн үр дүн	9,994,952,359.08	9,784,079,903.34
51220	Тайлант үеийн үр дүн	(216,472,315.93)	783,676,636.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	586,545,696.10	586,545,696.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,278,482,403.75	14,205,250,690.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	19,490,639,222.54	16,993,137,055.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,432,806,181.54	10,053,964,315.61
120	Нийтлэг татварын бус орлого	12,432,806,181.54	10,053,964,315.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,432,806,181.54	1,626,638,981.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,410,228,306.00	1,476,936,181.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	151,603,331.00	149,702,800.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	35,455,373.70	106,244,290.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,835,519,170.84	8,321,081,044.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,057,833,041.00	6,939,172,740.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,975,344,800.00	6,044,725,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,975,344,800.00	6,044,725,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,082,488,241.00	894,446,840.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,466,000.00	34,306,406.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,980,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,055,042,241.00	860,140,434.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	19,707,111,538.47	16,211,086,989.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,707,111,538.47	16,211,086,989.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,014,370,520.59	14,233,108,103.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,130,068,407.05	1,466,792,569.20
210101	Үндсэн цалин	702,016,744.47	859,633,647.19
210102	Нэмэгдэл	248,802,044.80	309,094,874.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,532,000.00	105,481,000.00
210104	Урамшуулал	103,717,617.78	192,583,047.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,313,572.74	199,118,510.31

210201	Тэтгэврийн даатгал	99,863,763.42	128,286,757.72
210202	Тэтгэмжийн даатгал	11,748,677.02	15,092,559.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,361,378.47	26,424,107.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,121,118.76	2,662,266.49
210205	Эрүүл мэндийн даатгал	21,218,635.07	26,652,818.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,318,554.10	145,504,893.62
210301	Гэрэл, цахилгаан	100,977,184.86	129,216,550.15
210302	Түлш, халаалт	11,470,646.24	11,430,123.39
210303	Цэвэр, бохир ус	4,870,723.00	4,858,220.08
2104	Хангамж, бараа материалын зардал	1,704,790,962.63	2,383,074,438.16
210401	Бичиг хэрэг	16,205,432.91	13,324,205.57
210402	Тээвэр, шатахуун	9,151,983.41	9,890,982.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,963,271.18	3,247,892.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,199,314.19	22,028,696.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,307,396.94	858,794.00
210408	Бараа материал ақталсны зардал	1,645,963,564.00	569,848,868.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	1,763,875,000.00
2105	Нормативт зардал	6,093,459,311.42	6,150,789,548.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,899,937,835.33	5,927,681,834.94
210502	Хоол, хүнс	193,283,076.09	216,395,914.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	238,400.00	6,711,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,890,764.00	64,807,731.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	885,500.00	-
210604	Урсгал засвар	36,005,264.00	64,807,731.00
2107	Томилолт, зочны зардал	750,000.00	236,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	750,000.00	236,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,726,801.24	89,593,086.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,020,659.24	67,483,854.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,062,500.00	11,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,210.00	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	318,352.00	315,152.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,988,500.00	8,497,500.00
210807	Газрын төлбөр	398,580.00	398,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,505,052,147.41	3,733,191,325.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,097,236,947.24	2,383,362,937.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,373,492.65	36,308,774.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,401,441,707.52	1,313,519,613.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,692,741,017.88	1,977,978,885.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	473,983,012.00	547,649,054.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,013,497.00	164,259,054.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	441,969,515.00	383,390,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,218,758,005.88	1,430,329,831.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,218,758,005.88	1,412,174,058.48
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,155,773.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(216,472,315.93)	782,050,066.51

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	1,626,570.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	1,626,570.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	1,626,570.00
5	НИЙТ ҮР ДҮН	(216,472,315.93)	783,676,636.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	11,203,455,267.05	10,990,340,373.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,101,817,026.05	3,728,043,494.90
120	Нийтлэг татварын бус орлого	4,101,817,026.05	3,728,043,494.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,101,817,026.05	3,728,043,494.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,965,460,834.50	3,582,928,094.90
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,356,191.55	145,115,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,101,638,241.00	7,262,296,878.32
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,975,344,800.00	6,044,725,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,975,344,800.00	6,044,725,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,126,293,441.00	1,217,570,978.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,466,000.00	34,306,406.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,980,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,098,847,441.00	1,183,264,572.32
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,197,743,951.88	10,827,776,561.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,197,743,951.88	10,827,776,561.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,959,780,525.68	8,348,676,410.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,133,774,585.34	1,464,787,732.79
210101	Үндсэн цалин	695,680,674.69	857,520,575.97
210102	Нэмэгдэл	258,844,292.87	309,227,392.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,532,000.00	105,481,000.00
210104	Урамшуулал	103,717,617.78	192,558,764.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,309,438.05	199,035,928.12
210201	Тэтгэврийн даатгал	99,855,593.84	128,247,374.66
210202	Тэтгэмжийн даатгал	11,747,715.90	15,087,926.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,359,648.43	26,378,895.93
210204	Ажилгүйдлийн даатгал	2,121,905.25	2,663,713.06
210205	Эрүүл мэндийн даатгал	21,224,574.63	26,658,017.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,563,554.10	145,476,893.62
210301	Гэрэл, цахилгаан	100,977,184.86	129,216,550.15
210302	Түлш, халаалт	11,470,646.24	11,430,123.39
210303	Цэвэр, бохир ус	5,115,723.00	4,830,220.08
2104	Хангамж, бараа материалын зардал	45,420,476.18	62,221,132.05
210401	Бичиг хэрэг	7,946,326.00	12,979,540.00
210402	Тээвэр, шатахуун	7,601,950.00	9,601,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,047,671.18	3,247,892.05

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,724,700.00	26,723,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	3,099,829.00	9,668,000.00
2105	Нормативт зардал	6,090,677,230.30	6,157,630,719.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,945,171,030.30	5,942,881,419.15
210502	Хоол, хүнс	141,863,900.00	211,179,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,642,300.00	3,570,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,753,084.00	102,997,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,219,500.00	3,096,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,274,100.00	623,700.00
210604	Урсгал засвар	35,259,484.00	99,277,300.00
2107	Томилолт, зочны зардал	736,600.00	236,000.00
210702	Дотоод албан томилолт	736,600.00	236,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,826,801.24	113,093,086.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,280,659.24	67,483,854.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,462,500.00	11,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,210.00	850,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	318,352.00	315,152.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,428,500.00	31,997,500.00
210807	Газрын төлбөр	398,580.00	398,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,718,756.47	103,197,418.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,855,502.17	64,932,812.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,863,254.30	38,264,606.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,237,963,426.20	2,479,100,150.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	473,983,012.00	547,449,054.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,013,497.00	164,259,054.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	441,969,515.00	383,190,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,763,980,414.20	1,931,651,096.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,445,445,275.88	1,412,174,058.48
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	318.535.138.32	519.477.037.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,711,315.17	162,563,811.83
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,240,000.00	163,855,127.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,240,000.00	163,855,127.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,240,000.00	163,855,127.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,240,000.00	163,855,127.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,240,000.00)	(163,855,127.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,471,315.17	(1,291,315.17)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,471,315.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	180,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	9,989,153,910.73	13,414,158,259.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,798,448.35	5,798,448.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	9,994,952,359.08	13,419,956,708.18
Тайлант үеийн үр дүн			(216,472,315.93)	(216,472,315.93)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	9,778,480,043.15	13,203,484,392.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,599,860.19	5,599,860.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	9,784,079,903.34	13,209,084,252.44
Тайлант үеийн үр дүн			783,676,636.51	783,676,636.51
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	10,567,756,539.85	13,992,760,888.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,443,346,900.00	8,361,886,651.59	81,460,248.41	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	8,443,346,900.00	8,361,886,651.59	81,460,248.41	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,274,791,300.00	8,194,837,597.59	79,953,702.41	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,464,966,100.00	1,464,787,732.79	178,367.21	99.9
Үндсэн цалин	858,945,400.00	857,520,575.97	1,424,824.03	99.8
Нэмэгдэл	351,286,000.00	309,227,392.27	42,058,607.73	88.0
Унаа хоолны хөнгөлөлт	106,150,000.00	105,481,000.00	669,000.00	99.3
Урамшуулал	148,584,700.00	192,558,764.55	(43,974,064.55)	129.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,885,900.00	199,035,928.12	8,849,971.88	95.7
Тэтгэврийн даатгал	134,079,600.00	128,247,374.66	5,832,225.34	95.6
Тэтгэмжийн даатгал	15,774,100.00	15,087,926.57	686,173.43	95.6
ҮОМШӨ-ний даатгал	27,612,500.00	26,378,895.93	1,233,604.07	95.5
Ажилгүйдлийн даатгал	2,763,500.00	2,663,713.06	99,786.94	96.3
Эрүүл мэндийн даатгал	27,656,200.00	26,658,017.90	998,182.10	96.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,236,100.00	145,476,893.62	14,759,206.38	90.8
Гэрэл, цахилгаан	141,933,400.00	129,216,550.15	12,716,849.85	91.0
Түлш, халаалт	11,900,000.00	11,430,123.39	469,876.61	96.0
Цэвэр, бохир ус	6,402,700.00	4,830,220.08	1,572,479.92	75.4
Хангамж, бараа материалын зардал	56,385,000.00	54,551,132.05	1,833,867.95	96.7
Бичиг хэрэг	13,007,300.00	12,979,540.00	27,760.00	99.7
Тээвэр, шатахуун	9,601,900.00	9,601,900.00	-	100.0

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,051,100.00	3,247,892.05	1,803,207.95	64.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26,724,700.00	26,723,800.00	900.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,998,000.00	2,000.00	99.9
Нормативт зардал	6,190,560,100.00	6,150,320,719.15	40,239,380.85	99.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,975,789,900.00	5,935,571,419.15	40,218,480.85	99.3
Хоол, хүнс	211,200,000.00	211,179,100.00	20,900.00	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,570,200.00	3,570,200.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	43,058,200.00	43,014,000.00	44,200.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	3,539,200.00	3,518,500.00	20,700.00	99.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	624,400.00	623,700.00	700.00	99.8
Урсгал засвар	38,894,600.00	38,871,800.00	22,800.00	99.9
Томилолт, зочны зардал	765,100.00	236,000.00	529,100.00	30.8
Дотоод албан томилолт	765,100.00	236,000.00	529,100.00	30.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,698,800.00	75,193,086.65	1,505,713.35	98.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,048,000.00	53,083,854.65	964,145.35	98.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,960,000.00	11,960,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	317,100.00	315,152.00	1,948.00	99.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,037,100.00	8,497,500.00	539,600.00	94.0
Газрын төлбөр	398,600.00	398,580.00	20.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	74,236,000.00	62,222,105.21	12,013,894.79	83.8
Бараа үйлчилгээний бусад зардал	74,236,000.00	62,222,105.21	12,013,894.79	83.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,555,600.00	167,049,054.00	1,506,546.00	99.1
Бусад урсгал шилжүүлэг	168,555,600.00	167,049,054.00	1,506,546.00	99.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	164,270,500.00	164,259,054.00	11,446.00	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,285,100.00	2,790,000.00	1,495,100.00	65.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,443,346,900.00	8,360,595,336.42	82,751,563.58	99.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,044,725,900.00	4,632,551,841.52	1,412,174,058.48	76.6
Улсын төсвөөс	6,044,725,900.00	4,632,551,841.52	1,412,174,058.48	76.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,398,621,000.00	3,727,863,494.90	(1,329,242,494.90)	155.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,268,621,000.00	3,582,748,094.90	(1,314,127,094.90)	157.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	145,115,400.00	(15,115,400.00)	111.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,471,315.17	(1,471,315.17)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	180,000.00	(180,000.00)	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	56	57	(1)	101.7
Үйлчлэх ажилтан	8	7	1	87.5
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	65	-	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	48	54	(6)	112.5
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	11	6	64.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,217,570,978.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,217,570,978.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		317,693,940.39
2104	Хангамж, бараа материалын зардал		25,610,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		25,610,000.00
2105	Нормативт зардал		7,310,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		7,310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		204,068,727.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,704,000.00
210602	Тавилга		13,050,000.00
210604	Урсгал засвар		166,314,727.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		14,400,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		25,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		41,305,213.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,040,607.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		38,264,606.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		899,877,037.93
2132	Бусад урсгал шилжүүлэг		380,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		380,400,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		519,477,037.93
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		519,477,037.93
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,217,570,978.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,217,570,978.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		34,306,406.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,183,264,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 180.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

Аудитаар нийт 53,361.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 25,904.0 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 27,457.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 53,361.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 213,595.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

Хариуцлага тооцох албан шаардлага

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 25,904.0 мянган төгрөгийн газар бүртгэлтэй боловч тухайн газар нь Эрүүл мэндийн яамны нэр дээр бүртгэлтэй, газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураггүй байна. Өмнөх аудитаар тус зөрчлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөрчлийг арилгаагүй, өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул дотоод аудитор С.Алтаннамарт хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт “Хараат бус аудиторууд, нягтлан бодогч, захирлуудын холбоо” ТББ-тай байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, 19,500.0 мянган төгрөгийг шилжүүлж, гэрээний дагуу ажлыг актаар хүлээж аваагүй боловч материалын дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материалын дансанд авах орлого, зарлагын гүйлгээнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, бараа материалыг хүлээж аваагүй байхад орлого авахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

2. Тооцооны дансны бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцагч байгууллагаас авах 6,200.3 мянган төгрөгийн авлагын, байгууллагад төлөх 1,757.6 мянган төгрөгийн өр төлбөрийн, нийт 7,957.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч нартай тооцоо нийлж, актаар баталгаажуулах, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар зөвлөмж өгөв.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 оноос хойш мөрдөж байгаа бөгөөд тус баримт бичигт дурдсан дансны төлөвлөгөө дахь үндсэн үйл ажиллагааны орлогын дансны эдийн засгийн ангиллыг зөрүүлэн шинжилгээний төлбөрийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих хэсэгт тусгаж буруу бүртгэсэн.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 727 мэдээллийг ил тод байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэг бүлэг болгон төлөвлөж, харьцуулалтын аргаар тендер зарлаж, худалдан авах боломжтой хөрөнгийг тус тусад нь салгаж, шууд гэрээ байгуулан нийт 23,439.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

3. Бараа материалын дансанд оны эхэнд үлдэгдэлтэй байсан тайлант онд ямар нэгэн хөдөлгөөн хийгээгүй 3 нэр төрлийн 17201 ширхэг, 5,209.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэглэлийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6- д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлж, их хэмжээгээр шаардлагагүй бараа, материал бэлтгэж, нөөцлөхгүй байхад анхаарч, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг банкны үлдэгдлийн баталгаатай тулгаагүй зөрүүтэй бүртгэсэн.	1	180.0					1	180.0				
Дүн	1	180.0					1	180.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичийг шинэчлэх асуудлаар “Хараат бус аудиторууд, нягтлан бодогч, захирлуудын холбоо” ТББ-тай гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн боловч гэрээний дагуу хийсэн ажлыг албан ёсоор хүлээж аваагүй байхад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	1	19,500.0					1	19,500.0				
Үндсэн хөрөнгийн бүртгэлд 25,904.0 мянган төгрөгийн газар эзэмших эрх бүртгэгдсэн боловч газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг байхгүй, тухайн газар нь Эрүүл мэндийн яамны нэр дээр бүртгэлтэй байна.	1	25,904.0							1	25,904.0		

Харилцагч байгууллагуудаас авах 6,200.3 мянган төгрөгийн авлага, мөн 1,757.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	7,957.9					1	7,957.9			
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 оноос хойш мөрдөж байгаа бөгөөд тус баримт бичигт дурдсан дансны төлөвлөгөө дахь үндсэн үйл ажиллагааны орлогын дансны эдийн засгийн ангиллыг зөрүүлэн шинжилгээний төлбөрийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих хэсэгт тусгаж буруу бүртгэсэн.	1	-					1	-			
Дүн	4	53,361.9					3	27,457.9	1	25,904.0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 727 мэдээллийг ил тод байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		
<i>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Бараа материалын дансанд оны эхэнд үлдэгдэлтэй байсан, тайлант онд хөдөлгөөн хийгдээгүй 3 нэр төрлийн 138 ширхэг нийт 5,209.1 мянган төгрөгийн бараа материал үлдэгдэлтэй байна.	1	5,209.1	1	5,209.1		
Дүн	1	5,209.1	1	5,209.1		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэг бүлэг болгон төлөвлөн харьцуулалтын аргаар тендер зарлан хөрөнгийг хоёр тусад нь салган худалдан авалт хийсэн байна.	1	23,439.9	1	23,439.9		
Дүн	1	23,439.9	1	28,439.0		
Нийт дүн	3	28,649.0	-3	28,649.0		